



I-IX/2021


Тархаасан: 2021 оны 10 дугаар сарын 8



Улсын хилээр орсон гадаадын зорчигчид өмнөх оны мөн үеэс 33.1 мянга буюу 54.7 хувиар буурчээ

Манай улсын хилээр 2021 оны эхний 9 сард 488.6 (давхардсан тоогоор) мянган зорчигч нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеэс 574.7 (54.1%) мянгаар буурчээ. Манай улсын хилээр 2021 оны эхний 9 сарын байдлаар 249.4 мянган зорчигч орсон байна. Улсын хилээр орсон зорчигчдын 22.4 хувь нь Гашуун сухайт, 19.0 хувь нь Замын-Үүд, 14.9 хувь нь Шивээ хүрэн, 7.4 хувь нь Буянт-Ухаа, 4.6 хувь нь Алтанбулаг, 31.7 хувь нь бусад боомтоор нэвтэрчээ. Улсын хилээр орсон зорчигчдын 221.9 (89.0%) мянга нь Монгол Улсын иргэд, 27.4 (11.0%) мянга нь гадаад улсын иргэд байна.

ЗУРАГ 1. МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР ОРСОН ЗОРЧИГЧИД, боомтоор, дүнд эзлэх хувиар, жилийн бүрийн эхний 9 сарын байдлаар



Энэ оны долоодугаар сард Монгол Улсын 4 415 иргэн тусгай үүргийн нислэгээр, 140 иргэн авто зам болон төмөр замын боомтуудаар, наймдугаар сард Монгол Улсын 4 081 иргэн тусгай үүргийн нислэгээр, 198 иргэн авто зам болон төмөр замын боомтуудаар, есдүгээр сард Монгол Улсын 2 968 иргэн тусгай үүргийн нислэгээр, 169 иргэн авто зам болон төмөр замын боомтуудаар тус тус ирсэн байна.

Улсын хилээр 2021 оны эхний 9 сард гадаадын 27.4 мянган хүн орсон нь өмнөх оны мөн үеэс 33.1 (54.7%) мянгаар буурчээ. Тэдний 83.2 хувь нь 30 хүртэл хоног, 2.8 хувь нь 30-аас 90 хүртэл хоног, 14.0 хувь нь 90, түүнээс дээш хоногийн хугацаагаар ирсэн байна. Хилээр орсон гадаадын зорчигчдын 4.7 (17.3%) мянга нь ажиллах, суралцах болон байнга оршин суух зорилгоор, харин 22.7 (82.7%) мянга нь аялал жуулчлалын зорилгоор ирсэн байна.

Аялал жуулчлалын зорилгоор хилээр орсон гадаадын зорчигчид өмнөх оны мөн үеэс 30.7 (57.5%) мянгаар буурсан байна. Өмнөх оны мөн үеэс БНХАУ-ын жуулчид 7 795 (65.5%), ОХУ-ынх 17 493 (65.7%), Өмнөд Солонгос Улсынх 4 016 (79.6%), Канад Улсынх 84 (53.8%) хүнээр тус тус буурчээ.

ХҮСНЭГТ 1. МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР ОРСОН ГАДААД ЗОРЧИГЧИД, бүс нутаг, улсаар, жил бүрийн эхний 9 сарын байдлаар

Бүс нутаг, улсаар	2018 I-IX	2019 I-IX	2020 I-IX	2021 I-IX
Бүгд	485 615	525 623	60 523	27 426
Зүүн Ази, Номхон далайн бүс нутаг	302 216	324 814	25 387	8 432
БНХАУ	165 435	166 130	15 161	5 546
БНСУ	76 896	91 345	5 483	1 234
Казахстан	14 078	13 810	1 501	602
Европ	151 925	165 078	32 271	15 592
ОХУ	102 012	112 253	27 860	10 479
Беларус	1 823	2 415	1 923	3 377
Герман	10 021	11 701	615	400
Америк	22 451	23 678	1 698	1 468
АНУ	16 577	17 467	1 289	1 274
Канад	3 766	3 843	289	135
Бразил	675	789	34	16
Өмнөд Ази	3 256	5 516	269	449
БНЭУ	2 096	2 257	209	244
Иран	198	234	19	14
Балба	302	358	13	11
Ойрх Дорнод	4 281	4 615	595	1 214
Турк	2 361	1 559	550	848
Израйл	878	1 074	20	5
Катар	408	862	11	117
Африк	1 449	1 888	300	270
Өмнөд Африк	916	1 352	251	181
Гана	20	20	9	2
Кени	27	39	9	4
Харьяалалгүй	37	34	3	1

Энэ оны эхний 9 сард улсын хилээр орсон гадаадын зорчигчдын 26.6 (97.2%) мянга нь насанд хүрсэн хүн, 779 (2.8%) нь хүүхэд, 24.5 (89.2%) мянга нь эрэгтэйчүүд, 2.9 (10.8%) мянга нь эмэгтэйчүүд байна. Улсын хилээр орсон гадаадын зорчигчдын 56.9 хувь нь Европ, 30.7 хувь нь Зүүн Ази, Номхон Далайн бүс нутаг, 5.4 хувь нь Америк, 7.0 хувь нь Ойрх Дорнод, Өмнөд Ази, Африк тивээс иржээ.

Хилээр орсон гадаадын зорчигчдын 20.2 хувийг БНХАУ-ын иргэд, 38.2 хувийг ОХУ-ын иргэд, 4.6 хувийг АНУ-ын иргэд, 4.5 хувийг БНСУ-ын иргэд, 12.3 хувийг Беларус, 2.2 хувийг Казахстан улсын иргэд, 18.0 хувийг бусад улсын иргэд тус тус эзэлж байна.

Манай улсын 214.9 (давхардсан тоогоор) мянган иргэн 2021 оны эхний 9 сард гадаадад зорчсоноос 89.9 (41.8%) мянга нь аялал жуулчлалын зорилгоор зорчсон нь өмнөх оны мөн үеэс 153.5 (63.1%) мянгаар, 125.0 (58.2%) мянга нь ажиллах, суралцах болон байнга оршин суух зорилгоор зорчсон нь өмнөх оны мөн үеэс 83.8 (40.1%) мянгаар тус тус буурчээ.

ХҮСНЭГТ 2. ГАДААДАД ЗОРЧСОН МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, улсаар, жил бүрийн эхний 9 сарын байдлаар


Зорчсон улсын нэр	2018 I-IX	2019 I-IX	2020 I-IX	2021 I-IX
БНХАУ	1 393 155	1 369 347	353 058	186 464
ОХУ	272 226	271 378	47 569	6 164
БНСУ	74 856	70 219	17 895	5 985
Япон	18 629	21 809	4 604	1 322
АНУ	10 563	11 995	2 318	3 421

Гадаадад зорчсон Монгол Улсын иргэдийн 200.8 (93.5%) мянга нь эрэгтэйчүүд, 14.1 (6.5%) мянга нь эмэгтэйчүүд, 2.5 мянга (1.2%) нь хүүхэд байна. Тэдний 204.3 (95.1%) мянга нь 30 хүртэл хоног, 1.2 мянга (0.6%) нь 30-аас 90 хүртэл хоног, 9.4 (4.3%) мянга нь 90, түүнээс дээш хоногийн хугацаагаар явсан байна.


Улсын хилээр 2021 оны эхний 9 сард 1 102.6 (давхардсан тоогоор) мянган тээврийн хэрэгслийг нэвтрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 198.6 (15.3%) мянгаар буурчээ. Тэдгээрийн 65.2 хувийг ачааны вагон, 32.9 хувийг ачааны машин, 0.1 хувийг суудлын машин, 1.8 хувийг бусад тээврийн хэрэгсэл эзэлж байна. Нийт тээврийн хэрэгслийн 56.3 хувь нь Замын-Үүд, 10.1 хувь нь Гашуун сухайт, 15.5 хувь нь Сүхбаатар, 6.7 хувь нь Шивээ хүрэн, 1.6 хувь нь Алтанбулаг, 9.8 хувь нь бусад боомтоор тус тус нэвтэрсэн байна.

ЗУРАГ 2. МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛСЭН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ, дүнд эзлэх хувиар, боомтын төрлөөр, жилийн бүрийн эхний 9 сарын байдлаар

2020 I-IX



2021 I-IX



Ойлголт, тодорхойлолт:

Монгол Улсын хилээр нэвтэрсэн зорчигчдод гадаадын болон дотоодын иргэдийг хамруулав. Монгол Улсын хилээр орсон зорчигчдыг зорилгоор нь албаны, хувийн, жуулчлал, дамжин өнгөрөх, суралцах, ажиллах, байнга оршин суух, бусад гэж ангилна.

Жуулчин: Байнга оршин суудаг газраасаа өөр газарт албаны, хувийн, жуулчлал, дамжин өнгөрөх, бусад зорилгоор 183 хоногоос доош хугацаагаар аялж буй гадаадын иргэн юм.



Эх үүсвэр:

Хил хамгаалах ерөнхий газар

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2022 оны 1 дүгээр сарын 14

Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын
дарга Ш.Ариунболд
Утас: (976-51)-261523

Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын
Хүн ам, орон сууцны тооллогын хэлтсийн
статистикч Ж.Цогзолмаа
Утас: (976-51)-267547

